



**БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ**

2024 оны 07 сарын 08 өдөр

Дугаар А/17

Улаанбаатар хот

“Багахангай тохижилт” Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын зарим албан тушаалын цалингийн хэмжээг шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх заалт, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 88 дугаар тогтоол, нийслэлийн Засаг даргын 2024 оны А/734 дүгээр захирамжийг тус тус үндэслэн Нийслэлийн Багахангай дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит XXVIII хуралдаанаас ТОГТООХ нь:

1. “Багахангай тохижилт” Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын цалингийн хэмжээг шинэчлэн хавсралтаар баталсугай.


2. “Багахангай тохижилт” ОНӨААТҮГ-ын зарим албан тушаалын цалингийн хэмжээ шинэчлэгдсэнтэй холбогдуулан төсвийн хүрээнд санхүүжүүлж ажиллахыг дүүргийн Засаг дарга (А.Сүхболд) -д даалгасугай.

3. Батлагдсан төсөвт багтаан зарим албан хаагчдын цалингийн хэмжээг шинэчлэн 2024 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн тооцож ажиллахыг “Багахангай тохижилт” ОНӨААТҮГ (Б.Гэрэлмаа)-т үүрэг болгосугай.

4. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Зөвлөлд даалгасугай.

5. Энэхүү тогтоол гарсантай холбогдуулан “Багахангай тохижилт” ОНӨААТҮГ-ын бүтэц орон тоо, цалингийн хэмжээг шинэчлэн батлах тухай” дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 04 дүгээр сарын 05-ны өдрийн А/10 дугаар тогтоолын хоёрдугаар хавсралтыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА



Ф.МӨНХГЭРЭЛ

Нийслэлийн Багахангай дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн
Хурлын 2024 оны 07 дугаар сарын 08-ны өдрийн
117 дугаар тогтоолын хавсралт

“БАГАХАНГАЙ ТОХИЖИЛТ” ОРОН НУТГИЙН ӨМЧИТ АЖ АХУЙН
ТООЦООТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН ЦАЛИНГИЙН ХЭМЖЭЭ

№	Албан тушаал	Цалингийн хэмжээ
Захиргаа, санхүүгийн хэсэг		
1	Захирал	1,800,000
2	Инженер	1,420,000
3	Ерөнхий нягтлан бодогч	1,400,000
4	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй хариуцсан ажилтан	1,240,000
5	Хүний нөөц, сургалт сурталчилгаа хариуцсан ажилтан	1,240,000
6	Хог хаягдал, орлогын байцаагч	1,060,000
7	Нярав, эд хариуцагч	1,100,000
8	Архив, бичиг хэрэг хариуцсан ажилтан	1,100,000
9	Үйлчлэгч	900,000
Нийтийн эзэмшлийн гудамж, зам талбайн арчилгаа үйлчилгээний менежементийг хэрэгжүүлэгч хэсэг		
1	Хэсгийн мастер	1,170,000
2	Зам талбайн үйлчлэгч	3,000,000
Хог хаягдлыг цуглуулан зөөж, тээвэрлэх менежементийг хэрэгжүүлэгч хэсэг		
1	Хэсгийн мастер	1,170,000
2	Хог тээврийн жолооч	3,000,000
3	Тусгай зориулалтын техникийн оператор	3,000,000
4	Ачигч	3,000,000
5	Мужаан	1,040,000
6	Төвлөрсөн хогийн цэгийн сахиул	900,000
7	Сахиул	1,000,000